

## **ХУРЛЫГ ХААЖ ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР Ph.D Д.ЗОЛБООГИЙН ХЭЛСЭН ҮГ**

Өнөөдрийн хуралд нийт 7 илтгэл хэлэлцүүлжээ. Үдээс өмнө гурван илтгэлийг хэлэлцлээ. Үндсэн илтгэгч Д.Базардорж докторын илтгэлээс гадна, хэлэлцээр байгуулагдсанаас хойших хоёр орны эдийн засаг-худалдааны харилцааг Н.Алтантөгс доктор, соёлын харилцааг нь Ж.Урангуа багш, Бөхөө доктор нар тус тусад нь авч, дагнасан хоёр илтгэлийг мөн хэлэлцсэн байна. Эдгээр илтгэлүүдэд хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны ерөнхий төрх агуулагдсан байна. Мөн харилцаа, хамтын ажиллагаа ямар түвшинд өрнөж байсныг өөр өөрийн өнцгөөр харуулсан, мөн нэлээн олон асуудлыг хамарсан, зарим зүйлийг шинээр гаргаж тавьсан, өргөн хүрээний судалгаа байж чадсан гэж бодож байна.

Үдээс хойших хуралдаанд үндсэн илтгэлүүдээс салбарласан 4 илтгэлийг хэлэлцлээ. Монгол дахь Хятад ажилчдын төлөөлөл болгож төмөр замын бүтээн байгуулалтад оролцсон хятад ажилчдын талаарх Х.Баатархүүгийн илтгэл сонирхолтой байлаа. Түүний илтгэлийн панелистүүд болох доктор Д.Наранжаргал, нийтлэлч А.Баатархуяг нарын ярианаас бид энэ чиглэлд холбогдох зарим сонирхолтой мэдээллийг авч чадсан байх гэж бодож байна.

Ц.Түмэнбаяр гуайн илтгэл үнэхээр сонирхолтой байлаа. Судлаач бидний барьж аваагүй, хийж гүйцэтгээгүй зүйлийг нийтлэлч, зохиолч нар маань маш сонирхолтой байдлаар гаргаж ирлээ гэж бодож байна. Бид цаашид хамтран ажиллах хэрэгтэй юм гэдгийг санууллаа.

Энэ хурлыг зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлсэн «Нэг бүс Нэг зам» олон улсын хөгжлийн академийн тэргүүн, профессор Лю танд бас маш их баярлалаа. Таны илтгэл орхигдоод байсан сэдвийг хөндсөн байна.

Манай хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Хишигтуяа сүүлийн илтгэлийг хэлэлцүүлсэн. Доктор Ц.Цэрэндорж, доктор Б.Энхчимэг нарын панелистүүд цаашдын судалгаандаа анхаарах үнэтэй санал зөвлөмжийг түүнд хэллээ. Түүхэн үзэгдэл асуудлыг олон талаас харахын зайлшгүй чухлыг сануулан хэлсэн панелистууддаа маш их баярлаж байна.

Энэ удаагийн хурлын явц дунд хуралд оролцогчдын байдлаас харахад ч тэр, зохион байгуулагчдын талаас харсан ч тэр дотоодын эрдэм шинжилгээний хурал биш, харин олон улсын эрдэм шинжилгээний хурал юм байна гэх шүүмжлэл гарсан. Ж.Урангуа багш, Бөхөө нарын илтгэл, Лю багшийн илтгэл гээд яривал хоёрын хоёр гадаад эрдэмтэн оролцсон байна. БНХАУ-ын ЭСЯ дэмжлэг үзүүлсэн. Мөн «Нэг бүс, нэг зам» олон улсын хөгжлийн академи бас дэмжин хамтран ажиллажээ. Гэхдээ бид энэ удаагийн хурлаа тэгж олон улсын хэмжээний гэж нэрлэхийг бодсонгүй нь юуны өмнө цар тахлын дараах нөхцөлд хийсэн хурал байсантай холбоотой юм. Ямартаа

ч эхний ээлжид хэлэлцээрийн 70 жилийн түүхийг бүгдээрээ дүгнэе, хэлэлцье л гэж бодож дотоодын хэмжээнд авч үзэн зохион байгуулсан юм. Төгсгөлд нь дүгнэхэд, 1952 оны энэхүү хэлэлцээр байгуулагдах түүхэн цаг үе, түүнээс хойш болсон үйл явдлууд, түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдол зэргийг нь хэлэлцэн дүгнэхээс гадна, тус хэлэлцээр нь баримт бичиг болохын хувьд тэрхүү баримт бичгийн шинж чанар, хэлбэр агуулга зэрэг асуудлыг ч мөн хөндсөн өргөн хүрээтэй, хэлэлцүүлэг сайтай эрдэм шинжилгээний хурал боллоо хэмээн үзэж байна.